

ИНТОСАИ-н Мэргэжлийн Стандартын Хороо

МСХ-Ажлын алба:

THE NATIONAL AUDIT OFFICE OF DENMARK • LANDGREVEN 4 • P.O. Box 9009 • 1022 COPENHAGEN • DENMARK
TEL.: +45 3392 8400 • FAX: +45 3311 0415 • E-MAIL: RIGSREVISIONEN@RIGSREVISIONEN.DK

INTOSAI



ИНТОСАИ-н Ерөнхий нарийн бичгийн даргын алба - RECHNUNGSHOF

(Австрийн Аудитын Шүүх)

DAMPFSCHIFFSTRASSE 2

A-1033 VIENNA

AUSTRIA

Tel.: ++43 (1) 711 71 • Fax: ++43 (1) 718 09 69

E-MAIL: intosai@rechnungshof.gv.at;

WORLD WIDE WEB: <http://www.intosai.org>

Агуулга

Өмнөх үг.....	4
I. Ерөнхий зүйл.....	5
II. Хараат бус байдал.....	6
III. Парламент, Засгийн газар, захиргааны байгууллагатай харилцах харилцаа.....	7
IV. Аудитын дээд байгууллагын эрх.....	8
V. Аудитын арга, аудитын ажилтан, улс хоорондын туршлага солилцоо.....	9
VI. Тайлагнал.....	10
VII. Аудитын дээд байгууллагын аудит хийх эрх.....	10

Эрхлэн хэвлүүлсэн:

Монгол Улсын Үндэсний аудитын газар,
ХБНГУ-ын ТХАН-ийн санхүүжилтээр хэрэгжсэн
“Үндэсний аудитын газарт дэмжлэг үзүүлэх” төсөл

Англи хэлнээс хөрвүүлсэн: Бадамдоржийн Батбаяр

Өмнөх үг

1977 оны 10 дугаар сард буюу 20 гаруй жилийн өмнө Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага ИНТОСАИ-н IX чуулганы төлөөлөгчид Перу улсын Лима хотноо Аудитын үндсэн зарчмуудын талаархи Лимагийн тунхаглалыг баталж байх үед энэ тунхаглал дэлхий нийтэд амжилт олох эсэх нь тодорхойгүй байсан хэдий ч ихээхэн итгэл найдвар тавьж байсан.

Тэр үеэс хойшхи Лимагийн тунхаглалыг хэрэгжүүлсэн туршлага хамгийн өөдрөг төсөөллийг ч давж, улмаар улс орон бүрийн онцлог нөхцөлд нийцүүлэн төрийн аудитын хөгжилд хэрхэн шийдвэрлэх нөлөө үзүүлж байгаа нь батлагдлаа. Лимагийн тунхаглал нь ИНТОСАИ-н бүсчлэлд багтсан нийт Аудитын дээд байгууллагуудын хувьд тэдний аль бүсэд хамрагдсан, хэр зэрэг хөгжсөн, тухайн орныхоо төрийн тогтолцоонд яаж уялддаг буюу хэрхэн зохион байгуулагдсан зэргээс хамаарахгүй ижил ач холбогдолтой.

Лимагийн тунхаглалын дээр дурдсан амжилт нь бүхэлдээ төрийн аудитын холбогдолтой бүхий л зорилго, асуудлуудын иж бүрэн жагсаалтыг өөртөө агуулсантай холбоотой бөгөөд ер бусын чухал ач холбогдолтой, товч тодорхой байдал нь түүнийг хэрэглэхэд дөхөм болгосны зэрэгцээ энгийн, ойлгомжтой хэллэг нь гол бүрэлдэхүүн хэсгүүдэд тусгалаа төвлөрүүлэх боломж олгожээ.

Лимагийн тунхаглалын үндсэн зорилго нь төрийн хараат бус аудитыг бүрдүүлэхийг уриалж буй явдал юм. Энэ шаардлагыг хангахгүй Аудитын дээд байгууллага стандартад үл нийцнэ. Тиймээс Аудитын дээд байгууллагуудын хараат бус байдлын асуудал ИНТОСАИ-н хамтын нийгэмлэгийн хүрээнд байнга хэлэлцэгдэж байдаг нь гайхмаар хэрэг биш ээ. Лимагийн тунхаглалын шаардлага нь дан ганц хараат бус байдлыг олж авснаар хангагдахгүй; энэхүү хараат бус байдлыг хууль тогтоомжид тусгаж өгөх шаардлагатай. Энэ үүднээс авч үзвэл, хууль эрхийн баталгаа бүхий сайн ажиллагаатай байгууллагууд байх ёстой бөгөөд тэдгээр нь гагцхүү хуулийг дээдэлсэн ардчиллын нөхцөлд л ажиллах боломжтой. Иймээс хууль дээдлэх ёс болон ардчилал нь төрийн үнэхээр хараат бус аудитын амин чухал нөхцөл бөгөөд Лимагийн тунхаглалын тулгуур баганууд юм. Тунхаглалд тусгагдсан зарчмууд мөнхийн, амин чухал үнэт зүйлс бөгөөд энэ нь тэдгээрийн цаг үеийн ач холбогдлыг анхлан нэвтрүүлсэн үеэс өнөөг хүртэл хэвээр хадгалсаар байна. 20 гаруй жилийн дараа энэ тунхаглалыг дахин нийтлэхээр шийдсэн нь үнэндээ түүнийг зохиогчид ямар чанартай бүтээл туурвисан, үзэл санаа нь хэр алсыг харсан байсныг гэрчилж байна.

Төрийн аудитын үндсэн хууль хэмээн зүй ёсоор үздэг энэхүү тулгуур баримт бичгийн үлэмж ач холбогдлыг үнэлэн, түүний шинэчилсэн найруулгыг хэвлэхэд хүчин зүтгэл гаргасан “Төрийн аудитын олон улсын сэтгүүл”-д талархлаа илэрхийлж байна. Лимагийн тунхаглал цаашид ч түгэн дэлгэрсээр байх болно гэдгийг бид одоо мэддэг боллоо. Энэ тунхаглалын өндөр дээд үзэл санаанд нийцэж ажиллах нь бид бүхний байнгын зорилт болж байна.

ИНТОСАИ-н Ерөнхий нарийн бичгийн дарга

Доктор, Франц Фийдлер

1998 оны намар, Вена хот

Оршил

Лимад болсон Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага ИНТОСАИ-н IX их хурал:

- ❑ нийтийн хөрөнгийг дэг журамтай, үр ашигтай ашиглах нь төрийн санхүүг зөв зохистой удирдах, холбогдох байгууллагаас гаргах шийдвэр үр нөлөөтэй байхын чухал урьдач нөхцөл учраас;
- ❑ энэ зорилгод хүрэхийн тулд улс орон бүр хараат бус байдал нь хуулиар баталгаажсан Аудитын дээд байгууллагатай байхын чухлыг тэмдэглэн;
- ❑ төрийн үйл ажиллагаа нийгэм, эдийн засгийн салбар руу өргөжиж, улмаар санхүүгийн уламжлалт хүрээ хязгаараас халих болсноос ийм байгууллага илүү чухал хэрэгцээтэй болж байгаа тул;
- ❑ аудитын тусгай зорилтууд, тухайлбал, нийтийн хөрөнгийг зөв, үр нөлөөтэй ашиглах; санхүүгийн зохистой удирдлагыг хөгжүүлэх; захиргааны үйл ажиллагааг сайтар хэрэгжүүлэх; үнэн бодитой тайланг хэвлэн нийтлэх замаар мэдээллийг төрийн байгууллага, олон нийтэд хүргэх зорилтууд нь улс орныг Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилгын дагуу тогтвортой байлгах болон хөгжүүлэхэд шаардлагатай болохыг ухамсарлан;
- ❑ ИНТОСАИ-н өмнөх их хурлууд, бүгд хурлын хуралдаануудаас тогтоол гаргаж, түүнийг түгээхийг бүх гишүүн орнууд дэмжсэнийг харгалзан;

ТОГТООХ нь:

“Аудитын үндсэн зарчмуудын талаархи Лимагийн тунхаглал” гэсэн нэртэй энэхүү баримт бичгийг хэвлэн нийтэлж түгээсүгэй.

1. Ерөнхий зүйл

Зүйл 1. Аудитын зориулалт

Нийтийн мөнгийг захиран зарцуулах нь итгэл дээр тулгуурладаг учир аудитын үзэл баримтлал, тогтолцоо нь төрийн санхүүгийн удирдлагад агуулагдаж байдаг. Аудит нь өөрөө эцсийн зорилго биш, харин зохицуулалтын тогтолцооны салшгүй хэсэг бөгөөд түүний зорилго нь тогтсон стандартаас гажсан, хууль ёс, санхүүгийн удирдлагын үр ашигтай, үр нөлөөтэй, арвигч хямгач байдлын зарчмыг зөрчсөн тохиолдлыг аль болох эрт илрүүлэн засаж залруулах боломж олгох, зарим тохиолдолд, холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэх, хохирлыг барагдуулах, иймэрхүү зөрчлөөс урьдчилан сэргийлэх буюу наад зах нь түүнийг багасгах арга хэмжээ авах явдал юм.

Зүйл 2. Урьдчилсан аудит ба үйл ажиллагааны дараах аудит

1. Урьдчилсан аудит нь захиргааны болон санхүүгийн үйл ажиллагааг хийгдэхээс нь өмнө шалгах явдал бөгөөд үйл ажиллагааны дараах аудит нь үйл ажиллагаа хийгдэж өнгөрсний дараа хийх аудит юм.
2. Тухайн улсын мэдэлд буй нийтийн хөрөнгийг ухаалаг удирдахад үр нөлөөтэй урьдчилсан аудит зайлшгүй шаардагдана. Үүнийг Аудитын дээд байгууллага, эсвэл аудитын бусад байгууллагууд хэрэгжүүлж болно.
3. Аудитын дээд байгууллагаас урьдчилсан аудит хийх нь аливаа хохирол учрахаас урьдчилан сэргийлэх боломж олгодог давуу талтай боловч ажлын ачааллыг ихэсгэж, хуулийн өмнө хүлээх хариуцлагыг бүрхэгдүүлэх сөрөг талтай. Аудитын дээд байгууллагаас хийдэг үйл ажиллагааны дараах аудит нь холбогдох этгээдийн хариуцлагыг тодруулахын хамт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчил давтагдахаас сэргийлэхэд чиглэгдэж болно.
4. Аудитын дээд байгууллага урьдчилсан аудит хийх эсэх нь тухайн орны хууль эрхийн орчин нөхцөл, шаардлагаар тодорхойлогдоно. Харин үйл ажиллагааны дараах аудит нь урьдчилсан аудит хийдэг эсэхээс үл хамааран Аудитын дээд байгууллага бүрийн зайлшгүй гүйцэтгэх чиг үүрэг юм.

Зүйл 3. Дотоодын аудит ба хөндлөнгийн аудит

1. Дотоод аудитын албыг засгийн газрын байгууллагын дотор байгуулдаг бол хөндлөнгийн аудитын алба нь шалгагдаж буй байгууллагын зохион байгуулалтын бүтцэд ордоггүй. Аудитын дээд байгууллага нь хөндлөнгийн аудитын алба юм.
2. Дотоод аудитын алба нь өөрөө бүрэлдэхүүнд нь багтдаг байгууллагын даргад зайлшгүй захирагдана. Гэхдээ холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил үүргийн болон зохион байгуулалтын хувьд аль болох хараат бус байх нь зүйтэй.
3. Аудитын дээд байгууллага хөндлөнгийн аудитор болохын хувьд дотоод аудитын үр нөлөөг шалгах үүрэгтэй. Дотоод аудитыг үр нөлөөтэй гэж үзвэл Аудитын дээд байгууллагын олон талт аудит хийх эрхэд хохирол учруулахгүйгээр Аудитын дээд байгууллага болон дотоод аудитын хооронд

чиг үүргээ аль болох оновчтой хуваарилан тогтоож, хамтран ажиллах талаар чармайлт гаргах нь зүйтэй.

Зүйл 4. Ёс журмын аудит, үнэн зөв байдлын аудит ба гүйцэтгэлийн аудит

1. Санхүүгийн удирдлага ба нягтлан бодох бүртгэл ёс журмын дагуу, үнэн зөв хэрэгжиж буй эсэхэд аудит хийх нь Аудитын дээд байгууллагын уламжлалт үүрэг юм.
2. Ач холбогдлоо хадгалсаар буй аудитын энэ төрлөөс гадна төрийн захиргааны гүйцэтгэл, арвич хямгач, үр ашигтай, үр нөлөөтэй байдлыг шалгахад чиглэгдсэн гүйцэтгэлийн аудит гэдэг түүнтэй ижил ач холбогдол бүхий аудитын хэлбэр бий. Гүйцэтгэлийн аудит нь санхүүгийн тодорхой үйл явцыг хамраад зогсохгүй мөн засгийн газрын үйл ажиллагааны бүхий л хүрээ, түүний дотор зохион байгуулалтын болон захиргааны тогтолцоог хамардаг.
3. Аудитын дээд байгууллагын аудитын зорилтууд болох санхүүгийн удирдлагын ёс журмын мөрдөлт, үнэн зөв, арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөт байдал нь үндсэндээ ижил ач холбогдолтой. Гэхдээ Аудитын дээд байгууллага өөрийн тэргүүлэх чиглэлээ тухайн тохиолдол бүрт тодорхойлж байна.

II. Хараат бус байдал

Зүйл 5. Аудитын дээд байгууллагын хараат бус байдал

1. Аудитын дээд байгууллага аудит хийгдэж буй байгууллагаас хараат бус байж, гадны нөлөөнөөс хамгаалагдсан нөхцөлд л зорилтоо бодитой бөгөөд үр нөлөөтэй хэрэгжүүлж чадна.
2. Төрийн аливаа байгууллага нийт төр улсын нэг хэсэг болохын хувьд бүр мөсөн хараат бус байх боломжгүй ч Аудитын дээд байгууллага зорилтоо хэрэгжүүлэхэд шаардагдах ажил үүргийн болон зохион байгуулалтын хараат бус байдалтай байна.
3. Аудитын дээд байгууллагыг үүсгэн байгуулсан тухай болон түүний хараат бус байдлын шаардагдах түвшинг Үндсэн хуульд тусгах бөгөөд нарийн ширийн зүйлийг холбогдох хуулиар зохицуулна. Тухайлбал, Аудитын дээд байгууллагын хараат бус байдал, аудитын бүрэн эрхэд хөндлөнгөөс нөлөөлөхийн эсрэг хууль эрхийн зохих хамгаалалтыг дээд шүүх баталгаажуулж өгөх нь зүйтэй.

Зүйл 6. Аудитын дээд байгууллагын гишүүд, ажилтнуудын хараат бус байдал

1. Аудитын дээд байгууллагын хараат бус байдал нь түүний гишүүдийн хараат бус байдалтай салшгүй холбоотой. Гишүүд гэж Аудитын дээд байгууллагын өмнөөс шийдвэр гаргах, гаргасан шийдвэрээ гуравдагч этгээдийн өмнө хариуцах хүмүүс, тухайлбал шийдвэр гаргах хамтын удирдлагат байгууллагын гишүүн буюу эсвэл ганцаарчилсан удирдлагатай Аудитын дээд байгууллагын даргыг хэлнэ.

2. Гишүүдийн хараат бус байдлыг Үндсэн хуулиар баталгаажуулна. Тухайлбал, үүрэгт ажлаас нь чөлөөлөх горим Үндсэн хуульд мөн тусгагдах бөгөөд гишүүдийн хараат бус байдалд муугаар нөлөөлөх учиргүй. Гишүүдийг томилох, чөлөөлөх арга хэлбэр тухайн улс орны Үндсэн хуулийн бүтцээс хамаарна.
3. Аудитын дээд байгууллагын ажилтнууд мэргэжлийн ажлаа хийх явцад аудит хийгдэж буй байгууллагын нөлөөнд өртөх болон тэдгээр байгууллагаас хараат байх ёсгүй.

Зүйл 7. Аудитын дээд байгууллагын санхүүгийн хараат бус байдал

1. Аудитын дээд байгууллага ажил үүргээ хэрэгжүүлэх боломж олгохуйц санхүүгийн хөрөнгөөр хангагдана.
2. Аудитын дээд байгууллага шаардлага гарвал хэрэгцээтэй санхүүгийн хөрөнгө авахаар улсын төсөв баталдаг төрийн байгууллагад шууд хандах эрхтэй байна.
3. Аудитын дээд байгууллага өөрт нь төсвийн тусгай зүйл анги болгон хуваарилсан санг өөрөө мэдэж ашиглах эрхтэй байна.

III. Парламент, Засгийн газар, захиргааны байгууллагатай харилцах харилцаа

Зүйл 8. Парламенттай харилцах харилцаа

Аудитын дээд байгууллага хэдийгээр Парламентын төлөөлөгч мэт ажиллаж, түүний заавраар аудит хийж байсан ч гэсэн Үндсэн хууль болон хуулиар тодорхойлсон хараат бус байдал нь мөн их хэмжээний өөрийн санаачлага, бие даасан байдлыг баталгаажуулж өгдөг. Аудитын дээд байгууллага болон Парламентын хоорондын харилцааг тухайн орны нөхцөл байдал, шаардлагатай уялдуулан Үндсэн хуулиар тодорхойлно.

Зүйл 9. Засгийн газар, захиргааны байгууллагуудтай харилцах харилцаа

Аудитын дээд байгууллага засгийн газар, түүний захиргааны байгууллагууд болон харьяа бусад байгууллагуудын үйл ажиллагаанд аудит хийнэ. Энэ нь гэхдээ засгийн газар Аудитын дээд байгууллагад захирагдана гэсэн үг биш. Тухайлбал, засгийн газар өөрийн үйлдэл, алдаа дутагдлынхаа хариуцлагыг дангаараа бүрэн хүлээх бөгөөд аудитын дүн нь хууль эрхийн хувьд хүчин төгөлдөр ба хэрэгжүүлбэл зохих шийдэл хэлбэрээр илэрхийлэгддэггүй л биш бол Аудитын дээд байгууллагын аудитын дүн болон шинжээчдийн санал дүгнэлтийг иш татан хариуцлагаас мултарч болохгүй.

IV. Аудитын дээд байгууллагын эрх

Зүйл 10. Мөрдөн шалгах эрх

1. Аудитын дээд байгууллага санхүүгийн удирдлагатай холбоотой бүх бүртгэл, баримт бичигт нэвтрэхээс гадна АДБ-ын шаардлагатай гэж үзсэн аливаа мэдээллийг амаар болон бичгээр шаардаж авах эрхтэй байна.
2. Аудитыг аудит хийгдэж буй байгууллага дээр хийх, Аудитын дээд байгууллагын байранд хийхийн аль нь ашигтай болохыг Аудитын дээд байгууллага тухай бүр шийдвэрлэнэ.
3. Аудитын дээд байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг, бусад бүртгэл, түүний дотор санхүүгийн тайланг ирүүлэх хугацааг хуулиар буюу эсвэл (тухайн тохиолдолд) Аудитын дээд байгууллага тогтооно.

Зүйл 11. Аудитын дээд байгууллагын аудитын дүнгийн хэрэгжилт

1. Аудит хийгдсэн байгууллага Аудитын дээд байгууллагын аудитын дүнгийн талаар хуулиар ерөнхийлөн заасан буюу эсвэл Аудитын дээд байгууллагаас нарийвчлан тогтоосон хугацаанд тайлбар хийх бөгөөд аудитын дүнгийн мөрөөр авсан арга хэмжээгээ мэдэгдэнэ.
2. Аудитын дээд байгууллагын аудитын дүн хууль эрхийн хувьд хүчин төгөлдөр бөгөөд хэрэгжүүлбэл зохих шийдэл хэлбэрээр илэрхийлэгддэггүй тохиолдолд шаардлагатай арга хэмжээ авах эрх бүхий байгууллагад Аудитын дээд байгууллага хандаж холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэхийг хүсэх эрхтэй байна.

Зүйл 12. Шинжээчийн санал бодол ба зөвлөх эрх

1. Шаардлагатай үед Аудитын дээд байгууллага шинжээчийн санал бодол, түүний дотор хуулийн төсөл, санхүүгийн бусад дүрэм журмын талаархи санал зөвлөмж хэлбэрээр Парламент болон захиргааны байгууллагуудыг мэргэжлийн мэдлэгээр хангаж болно. Шинжээчийн энэхүү санал бодлыг хүлээн авах эсэх нь захиргааны байгууллагуудын эрх мэдлийн асуудал төдийгүй энэхүү нэмэлт ажил үүрэг нь Аудитын дээд байгууллагын цаашдын аудитын дүнг урьдчилан илтгэх, аудитын үр нөлөөт байдалд сөргөөр нөлөөлөх ёсгүй.
2. Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой, аль болох ижилсүүлсэн журмыг гагцхүү Аудитын дээд байгууллагатай зөвшилцсөний дараа нэвтрүүлж байна.

V. Аудитын арга, аудитын ажилтан, улс хоорондын туршилага солилцоо

Зүйл 13. Аудитын арга ба горим

1. Аудитын дээд байгууллага өөрийн тодорхойлсон хөтөлбөрийн дагуу аудит хийнэ. Тодорхой аудит хийлгэхийг хүсэх талаархи төрийн зарим байгууллагын эрх хэвээр хадгалагдана.
2. Аудит нь бүх асуудлыг хамарсан байх нь ховор тул Аудитын дээд байгууллага гол төлөв түүвэрлэх аргыг хэрэглэх шаардлагатай тулгардаг. Ингэхдээ, түүврийг тодорхой загварын үндсэн дээр сонгох бөгөөд түүний тоо нь санхүүгийн удирдлагын чанар, үнэн зөв байдлыг үнэлэх боломж өгөхүйц хангалттай байна.
3. Аудитын аргыг санхүүгийн удирдлагатай холбогдох шинжлэх ухаан, техникийн дэвшилтэй байнга уялдуулж байна.
4. Аудитын дээд байгууллага аудиторууддаа туслах зорилгоор аудитын гарын авлага бэлтгэх нь зүйтэй.

Зүйл 14. Аудитын ажилтнууд

1. Аудитын дээд байгууллагын гишүүд болон ажилтнууд ажил үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах мэргэшил, шударга ёс суртахуунтай байна.
2. Аудитын дээд байгууллага ажилтан элсүүлж авахдаа дундаас дээш түвшний мэдлэг, ур чадвартай бөгөөд мэргэжлийн зохих туршлагатай хүмүүсийг чухалчлах хэрэгтэй.
3. Байгууллагын дотоод болон их, дээд сургууль, олон улсын сургалтад хамруулах аргаар Аудитын дээд байгууллагын бүх гишүүд, ажилтнуудын мэргэжлийн мэдлэгийг онол, практикийн хувьд дээшлүүлэхэд онцгой анхаарвал зохино. Үүнийг санхүүгийн болон зохион байгуулалтын бүхий л арга хэрэгслээр дэмжих нь зүйтэй. Мэргэжлийн сургалт нь эрх зүй, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн удамжлалт хүрээнээс хальж, цахим мэдээлэл боловсруулалт зэрэг бизнесийн удирдлагын бусад техникийг хамрах нь зүйтэй.
4. Дээд зэргийн чанартай аудитын ажилтантай байхын тулд энэхүү ажлын онцлог шаардлагад тохирсон цалин олгоно.
5. Аудитын ажилтнуудын дунд тодорхой асуудлаархи ур чадвар хэрэв дутагдаж байвал Аудитын дээд байгууллага гадны шинжээчдийн туслалцааг шаардлагатай хэмжээгээр авч болно.

Зүйл 15. Улс хоорондын туршлага солилцоо

1. Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллагын хүрээнд улс орнууд санал бодол, туршлагаа солилцох нь Аудитын дээд байгууллагад ажил үүргээ хэрэгжүүлэхэд нь туслах үр нөлөөтэй арга зам юм.
2. НҮБ болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан их хурал, сургалт семинар, бүс нутгийн ажлын хэсгүүд, мэргэжлийн сэтгүүл зэрэг нь энэхүү зорилгод үйлчилсээр ирсэн.
3. Эдгээр хүчин чармайлт, үйл ажиллагааг өргөжүүлж, эрчимжүүлэх нь зүйтэй. Харьцуулсан хууль эрхийн үндсэн дээр төрийн аудитын хэвшмэл нэр томъёог боловсруулах нь тэргүүлэх ач холбогдолтой болно.

VI. Тайлагнал

Зүйл 16. Парламент болон олон нийтэд тайлагнах нь

1. Аудитын дээд байгууллага Үндсэн хуулийн дагуу үйл ажиллагааныхаа үр дүнг Парламент буюу эсвэл эрх бүхий төрийн бусад байгууллагад жил тутам бие даан тайлагнах эрх, үүрэгтэй бөгөөд уг тайланг хэвлэн нийтэлнэ. Энэ нь Аудитын дээд байгууллагын аудитын дүнг олон нийтэд өргөн хэмжээгээр хүргэж, хэлэлцүүлэхийн хамт хэрэгжих боломжийг нь дээшлүүлнэ.
2. Аудитын дээд байгууллага түүнчлэн оны явцад онцгой чухал, ач холбогдолтой гэж үзсэн аудитын дүнг тайлагнах эрхтэй байна.
3. Ер нь жилийн тайланд Аудитын дээд байгууллагын бүхий л үйл ажиллагаа тусгагдах учиртай; гэхдээ хамгаалбал зохих буюу эсвэл хуулиар хамгаалагдсан сонирхол хөндөгдөж байвал Аудитын дээд байгууллага тухайн сонирхлыг түүнийг нийтэд дэлгэсний ашиг тустай харьцуулан сайтар цэгнэх нь зүйтэй.

Зүйл 17. Тайлагнах арга

1. Тайланд тоо баримт, тэдгээрийн үнэлгээг бодитой, тодорхой байдлаар тусгах бөгөөд зөвхөн зайлшгүй чухал зүйлс агуулагдсан байна. Тайлангийн үг хэллэг оновчтой бөгөөд ойлгоход хялбар байна.
2. Аудитын дээд байгууллага аудитын дүнгийн талаархи аудит хийгдсэн байгууллагын санал бодолд зохих анхаарал хандуулна.

VII. Аудитын дээд байгууллагын аудит хийх эрх

Зүйл 18. Аудит хийх эрхийн Үндсэн хуулийн үндэслэл, төрийн санхүүгийн удирдлагын аудит

1. Аудитын дээд байгууллагын аудит хийх үндсэн эрх Үндсэн хуульд тусгагдсан байх бөгөөд нарийн ширийн зүйлийг хуулиар зохицуулна.

2. Аудитын дээд байгууллагын аудит хийх эрхийн бүрэлдэхүүн хэсгүүд нь тухайн улс орны нөхцөл байдал, шаардлагаас хамаарна.
3. Төрийн санхүүгийн бүхий л ажиллагаа улсын төсөвт тусгагдсан буюу хэрхэн тусгагдсан эсэхээс үл хамааран Аудитын дээд байгууллагын хяналтад байна. Санхүүгийн удирдлагын зарим хэсгийг улсын төсөвт тусгаагүй орхисон нь тэдгээр хэсгийг Аудитын дээд байгууллагын аудитад хамруулахгүй байх үндэслэл болохгүй.
4. Аудитын дээд байгууллагууд өөрсдийн аудитаар дамжуулан нарийн тодорхойлсон төсвийн ангилал, аль болох хялбар, тодорхой нягтлан бодох бүртгэлийн тогтолцоог дэмжих ёстой.

Зүйл 19. Хилийн чанад дахь төрийн болон бусад байгууллагын аудит

Зарчмын хувьд Аудитын дээд байгууллага хилийн чанадад байгуулагдсан төрийн байгууллага болон бусад байгууллагад аудит хийнэ. Эдгээр байгууллагад аудит хийхдээ олон улсын хуулиар тогтоосон хязгаарлалтуудыг сайтар анхаарах ёстой бөгөөд хэрэв үндэслэл олж тогтоовол эдгээр хязгаарлалтыг олон улсын хуулийг боловсронгуй болгох явцад арилгавал зохино.

Зүйл 20. Татварын аудит

1. Аудитын дээд байгууллага татвар хураалтад аль болох өргөн хүрээтэй аудит хийх, ингэхдээ татварын нэгж баримтыг ч шалгах эрхтэй байна.
2. Татварын аудит нь үндсэндээ ёс журмын болон үнэн зөв байдлын аудит юм; гэхдээ Аудитын дээд байгууллага татварын хуулийн хэрэгжилтэд аудит хийх явцдаа татвар хураалтын тогтолцоо, үр нөлөөт байдал, орлогын төлөвлөгөөний биелэлтийг шалгаж, хэрэв зохимжтой бол, түүнийг сайжруулах арга замыг хууль тогтоох байгууллагад санал болгоно.

Зүйл 21. Улсын гэрээ, барилга байгууламжийн ажлын аудит

1. Гэрээ контракт болон барилга байгууламжийн ажилд төрийн байгууллагууд ихээхэн хөрөнгө зарцуулдаг нь ашигласан хөрөнгөд нягт нямбай аудит хийхийг шаардана.
2. Нээлттэй тендер шалгаруулалт нь үнэ, чанарын хувьд хамгийн боломжийн санал авах нэн тохиромжтой горим юм. Хэрэв нээлттэй тендер шалгаруулалт хийгдээгүй бол Аудитын дээд байгууллага шалтгааныг нь тодорхойлох нь зүйтэй.
3. Барилга байгууламжийн ажилд аудит хийхдээ Аудитын дээд байгууллага ийм ажлыг удирдах асуудлыг зохицуулсан тохиромжтой стандарт боловсруулж нэвтрүүлэх явдлыг дэмжих нь зүйтэй.
4. Барилга байгууламжийн ажлын аудит нь төлбөр тооцоо үнэн зөв хийгдсэн эсэхийг шалгаад зогсохгүй, барилгын ажлын удирдлагын үр ашиг болон барилгын ажлын чанарыг мөн хамарна.

Зүйл 22. Мэдээлэл боловсруулах цахим төхөөрөмжийн аудит

Мэдээлэл боловсруулах цахим төхөөрөмжид ихээхэн хөрөнгө зарцуулж байгаа нь зохих аудит хийхийг шаардаж байна. Ийм аудит нь системд-суурилсан бөгөөд хэрэгцээ шаардлагын төлөвлөлт; мэдээлэл боловсруулах тоног төхөөрөмжийн ашиглалтын арвич хямгач байдал; зохих мэргэжлийн мэдлэгтэй хүмүүсийг болж өгвөл тухайн байгууллагын удирдлага дотроос ашиглаж буй эсэх; зүй бус ашиглалтаас сэргийлэх; боловсруулсан мэдээллийн ашиг тус зэрэг асуудлыг хамарна.

Зүйл 23. Төрийн оролцоотой үйлдвэр, аж ахуйн нэгжүүд

1. Засгийн газрын эдийн засгийн үйл ажиллагаа өргөжих нь ихэвчлэн хувийн хэвшлийн хууль эрхийн үндсэн дээр үйлдвэр, аж ахуйн нэгж байгуулахад хүргэдэг. Хэрэв тэдгээрт засгийн газар их хэмжээний оролцоотой буюу ялангуяа давамгайлсан, зонхилсон байдалтай оролцож байвал Аудитын дээд байгууллага тэдгээр үйлдвэр, аж ахуйн нэгжид аудит хийнэ.
2. Ийм аудит үйл ажиллагааны дараах аудитын хэлбэртэй байх нь зохимжтой бөгөөд арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөний асуудлыг хөндөх нь зүйтэй.
3. Эдгээр үйлдвэр, аж ахуйн нэгжид хийсэн аудитын дүнг Парламент болон олон нийтэд тайлагнахдаа үйлдвэрлэлийн болон арилжааны нууцыг хамгаалах зориулалттай хязгаарлалтуудыг анхаарах нь зүйтэй.

Зүйл 24. Төсвөөс санхүүждэг байгууллагын аудит

1. Аудитын дээд байгууллага улсын төсвөөс олгосон санхүүжилтийн ашиглалтад аудит хийх эрхтэй байна.
2. Санхүүжилт нь өөрөө буюу эсвэл санхүүжилт авсан байгууллагын орлого, хөрөнгөтэй харьцуулахад ихээхэн өндөр байвал аудитыг, шаардлагатай гэж үзвэл, санхүүжилт авсан байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүхэлд нь хамруулан өргөжүүлж болно.
3. Санхүүжилтийг зүй бусаар ашигласан бол нөхөн төлүүлэх шаардлага тавина.

Зүйл 25. Олон улсын болон үндэстэн дамнасан байгууллагын аудит

1. Гишүүн орнуудын хувь нэмрээр зардлаа даалгадаг олон улсын болон үндэстэн дамнасан байгууллагууд нь тухайн орнуудынх шиг хөндлөнгийн, хараат бус аудит хийгдэх субъект болно.
2. Ийм аудитад хэдийгээр ашигласан нөөцийн түвшин, тэдгээр байгууллагын ажил үүргийг харгалзан үздэг боловч гишүүн орнуудын Аудитын дээд байгууллагын хийдэг аудитынхтай ижил зарчмуудыг баримтлах нь зүйтэй.
3. Ийм аудитын хараат бус байдлыг хангах үүднээс хөндлөнгийн аудитын байгууллагын гишүүдийг гол төлөв Аудитын дээд байгууллагуудаас томилох нь зүйтэй.